



БОГД БАНК
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2024.07.02

№ 4/89

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12, 80 дугаар зүйлийн 80.6, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, Банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14.10, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Богд банк” ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн урьдчилсан байдлаарх татварын дараах цэвэр ашгийн 25 хувь болох 3,752,801,206.64 төгрөгийг 1,250,000,000.00 ширхэг хувьцаанд ногдуулж, нэгж хувьцаанд 3.00 төгрөгийг мөнгөн хэлбэрээр хуваарилсугай
2. Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангасан болохыг дурдсугай.
3. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг энэхүү тогтоол гарсан өдрөөр буюу 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөр тогтоосугай.
4. Монголбанкнаас ногдол ашиг хуваарилах зөвшөөрөл ирснээс хойш 60 хоногийн дотор энэхүү тогтоолын 1-д заасан ногдол ашгийг тараасугай.
5. Энэхүү тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 3-ны өдөрт багтаан банкны өөрийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж хувьцаа эзэмшигч нарт мэдэгдсүгэй.
6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилахыг дурдсугай.
7. Хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалт гаргах өдрөөс хойш ногдол ашиг хуваарилах хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулагдсан гэрээнд өөрөөр заагаагүй бол хувьцааны хуучин эзэмшигчид ногдол ашиг хуваарилагдах болохыг дурдсугай.
8. Тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Саруулд/ үүрэг болгосугай.
9. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д тус тус хүргүүлсүгэй.

10. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар /Д.Төрмандах/-
т үүрэг болгосугай.
11. Ногдол ашиг хуваарилалтын тайланг банкны хувьцаа эзэмшигчдийн дараагийн
хуралд танилцуулж тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Л.Болдхуяг/-д
даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Л.БОЛДХУЯГ